

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2022 ОНЫ ТАЙЛАН
(ДОРНОД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР)**

2023.01.08.

ЧОЙБАЛСАН ХОТ

Ший двэр Д/д	Заа лт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөри йн үнэл гээ	Дээд шатны байгуул лын үнэлгээ	Үнэлгээ ний тайлба р
Монгол Улсын хууль							
1	1	Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай 2017-05-12 Дугаар 2017.05.12	14.2.2. Эх, нялх, балчир хүүхдийн эрүүл хүнс, зөв хооллолтыг дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, хэрэгжилтийг хангах:	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/245 дугаар тушаалаар хүүхдийн хоол тэжээлийн хөтөлбөрийн хүрээнд 6-59 сартай хүүхдэд өндөр тунт А аминдэмийг хуваарилан аймгийн хэмжээнд нийт 17787 ширхэг 1,503,231 төгрөгийн өртөг бүхий аминдэм олгогдож, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд бүрэн хуваарилан олгосон. Бага насны хүүхдэд олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг 12 сумын эрүүл мэндийн төвд нийт 43980 уут бэлдмэл, зорилтот бүлгийн жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд зориулсан 27000 шахмал уух бэлдмэлийг тус тус түгээсэн. Нийгмийн эрүүл мэндийн төвд хоол зүйн кабинетийг шинээр тохижуулан ашиглалтанд оруулсан, 2023 онд иргэдэд эрүүл зохистой хооллолт, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгааг хийхээр төлөвлөн ажиллаж байна.	70		
2			7.1.11. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах; (7.1.Цартахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх	“Коронавируст халдвар”-ын Омикрон хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх, коронавирусийн халдварын эсрэг нэмэлт дархлаажуулалтад иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Хэрлэн сумын 11 багийн 144 хэсгийн ахлагч, улаан загалмайн хорооны 66 сайн дурын ажилтнуудтай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр	100		

		сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11,1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	эрхлэгчид, иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулсан. Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим хуудсанд давхардсан тоогоор 815 зөвлөмж байршуулан, хандалт 45762, давхардсан тоогоор 3127 төрлийн, 18621 ширхэг гарын авлага, зөвлөмжийг иргэдэд түгээсэн. Цартахлаас урьдчилан сэргийлэх мэдээллийг https://www.dornod.moh.gov.mn , https://www.facebook.com/dornodemgazar цахим хуудсаар тогтмол нийтэлж ажилладаг.			
		7.1.13.. Төрөлжсөн асрамжийн газар, түүнчлэн эрүүлжүүлэх, баривчлах, цагдан хорих байр, хорих ангид байгаа болон бусад хэлбэрээр эрх чөлөө нь хязгаарлагдсан иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11,1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	Зүүн бүсийн Ахмад настны асрамж, халамжийн төвийн асруулагч 8 ахмад настанд зөвлөх үйлчилгээний багийн эмч, “Мянган жаргалан” өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран биеийн ерөнхий үзлэг хийж, сувилахуйн тусламж үйлчилгээг 2 удаа үзүүлсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Хэнтий аймгийн засан хүмүүжүүлэх газарт очих 5 хүмүүжигчээс PCR шинжилгээ авч хариуг хүргүүлэн тус газарт хоригдож буй 10 иргэнийг төрөлжсөн мэргэжлийн эмчийн тусламж, үйлчилгээнд хамруулж 3 иргэнийг хэвтэн эмчлүүлсэн. Ягаан цээнэ өрхийн эрүүл мэндийн төвөөс тус байранд цагдан хоригдож байгаа иргэдэд гар ариутгагч, амны хаалт, ариун цэврийн хэрэгсэл, аминдэмүүлэлтээр хангасан байна.	100		
		7.1.16. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан	Тайлант онд цар тахалтай холбоотой тусгай горимд шилжин ажилласан тохиолдол гараагүй болно.	-		

			шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)			
	2		7.1.21. Цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, ийм үйл ажиллагааг хуульд заасан аргаар таслан зогсоох; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11,1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	Тус аймагт 26234 коронавируст халдварын тохиолдол бүртгэгдсэн бөгөөд халдвар авсан иргэдээс ялгаварлан гадуурхагдсан талаар өргөдөл гомдол бүртгэгдээгүй болно.	100	
3	3		7.1.22. Цар тахлын үед арга хэмжээ авахдаа хүүхэд болон өндөр настай, хууч өвчтэй, эрүүл мэндийн тогтмол тусламж, үйлчилгээ шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Дорнод аймгийн нийт хүн амын 26234 иргэн буюу 31.0 хувь нь коронавируст халдвар "COVID-19"-халдвар авсан байна. Тус халдвар авсан өндөр настай болон архаг хууч өвчтэй иргэдэд илэрч буй ковидын дараах хам шинжийг эмчлэх зорилгоор ОНТ-ийн 62.5 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Засаг даргын 2022 оны А/47 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Уламжлалт анагаах ухааны төв, хувийн хэвшлийн "Наран", "Баянбүрд" мэдрэл, сэргээн засах үүдэн эмнэлэг, 13 сумын Эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн сэргээн засах зуны сувиллыг 2022 оны 06 дугаар сараас ажиллуулж, хамрагдвал зохих зорилтот бүлгийн 1350 иргэнийг 100 хувийг хамруулсан бөгөөд сэргээн засах, эмийн эмчилгээ, эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөнөөр эрүүлжүүлэн чийрэгжүүлж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.	100	
	4			Улсын эрүүл мэндийн 17 байгууллага, 31 хувийн хэвшлийн нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж жилийн эцсийн байдлаар суманд 85 хувь, аймгийн төвд 93 хувьтай байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас	100	

				олгох хөнгөлөлттэй эмийн санхүүжилтэд хязгаарлалт тогтоохгүй, бүх шатлалын эмч нар хөнгөлөлттэй эмийн цахим жорыг бичиж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн 37 эмийн сангаар 102,8 сая төгрөгийн эм зүйн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хангах боломжийг нэмэгдүүлсэн.			
УИХ-ЫН ТОГТООЛ							
4	8		1.2/з/. хүүхдийн бэлгийн эрүүл мэнд, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг ерөнхий боловсролын сургуулийн түвшинд үр дүнтэй зохион байгуулах арга замыг тодорхойлж, хүүхдийн нууцыг чанд хадгалдаг, итгэлийг нь хүлээдэг тогтолцоог сургуульд бүрдүүлэх;	ЕБС-ийн 15-18 насны 1460 сурагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, тэмбүүгийн 5, заг хүйтний 6, мөөгөнцөрийн 17 халдвар, шээсний сувгийн үрэвсэлт 2 өвчлөлийг илрүүлж, 100 хувь эмчилгээнд хамруулсан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/19 дугаар захирамжаар "Аз жаргал төв"-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн 25 сая төгрөгийн санхүүжилттэй төсөл арга хэмжээг баталж, төслийг хэрэгжүүлэхээр "Ашид батжин" ТББ шалгаран ажил гүйцэтгэх гэрээ байгуулан оюутан, залуучууд, өсвөр үеийн сурагчдад сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Аз жаргал төвөөр тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 7068 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлж, өмнөх оны мөн үеэс 536 хүүхдээр нэмэгдсэн байна. Шинээр 45 оюутан сургагч багшаар бэлтгэж, үе тэнгийн 262 сургагч багшийг чадавхжуулсан.	100		
	9		1.2/и/. эмнэлгийн стандарт, шаардлага хангаагүй нөхцөлд нууцаар үр хөндөх, хяналтгүйгээр үр зулбуулах эм зардаг байдлыг илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх тодорхой арга хэмжээг авах;	Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чиглэлээр тусгай зөвшөөрөл бүхий 2 хувийн хэвшлийн эмнэлэг үйл ажиллагаа явуулдаг. Тайлант онд хийгдсэн хяналт үнэлгээгээр үр хөндөх, үр зулбуулах эм зарсан тохиолдол гараагүй. Мөн 5 эм ханган нийлүүлэх байгууллага, нийтийн үйлчилгээтэй 23 эмийн санд хийсэн	100		

				хяналтаар үр зулбуулах эм худалдан борлуулсан зөрчил илрээгүй.			
5	10	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62	1.4/б/. эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг оруулж, үе шаттайгаар зохион байгуулах;	ХНХЯам, Аймгийн ЗДТГ, ХХУГ, ЭМГ, БШУГ хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах” бүсийн сургалтыг зохион байгуулж, салбар комиссын гишүүд болон эрүүл мэндийн салбараас 60 төрийн албан хаагчид оролцож чадавхжсан.	100		
	11		1.4/в/. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн үржихүйн кабинет, төрөх тасгуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах;	Аймгийн хэмжээнд нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийн гурван кабинет үйл ажиллагаа тогтмол явуулж байгаа бөгөөд амбулаторийн хэсэг рүү үйлчлүүлэгч орох хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг өргөтгөн сайжруулсан.	100		
	12		1.7/г/. Уул уурхайн салбарт ажиллагсдыг осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын байрны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, мэргэжлээс шалтгаалах өвчин, урьдчилан сэргийлэх талаар 312 ажилтанд сургалт зохион байгуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг зөрчихгүй байхыг сануулсан 7 тэмдэг, тэмдэглэгээ, 3 анхааруулга, 4 сэрэмжүүлэгийг байршуулан ажиллах талаар мэдээлэл, зөвлөмжийг хүргүүлсэн. Тусгаар тогтнолын талбайд болсон тус аяны нээлтийн арга хэмжээнд халдварт болон халдварт бус өвчин, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс	100		

				урьдчилан сэргийлэх 8 төрлийн 150 гаруй гарын авлага түгээсэн.			
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
6	25	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ	3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик ирүүлэх)	<p>“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ”-ний хүрээнд “Бэлгийн замаар дамжих халдвар болон сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах” төсөл арга хэмжээг 60 сая төгрөгөөр санхүүжүүлэн зорилтот бүлгийн 10000 иргэнийг үзлэгт хамруулахаар төлөвлөж ажилласан ба хамрагдалт 9500 буюу 95 хувь байна.</p> <p>Хэрлэн сумын эрсдэлт бүлгийн 900 гаруй иргэд, ЕБС-ийн 15-18 насны 1460 сурагч, ПТК, ДИС, МСҮТ-ийн 755 оюутан залуус, 10 төрийн байгууллагын 1000 гаруй албан хаагчид, Уул уурхайн 370 ажилчин албан хаагчид, 13 сумын зорилтот бүлгийн 600 иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, тэмбүүгийн 11, заг хүйтний 10, трихоминиаз 16, мөөгөнцрийн 24, шээсний сувгийн үрэвсэлт 10 өвчлөлийг илрүүлэн, 100 хувь эмчилгээнд хамруулсан. Хавьтлын илрүүлэлт 85.0 хавьтлын эмчилгээ 80 хувь.</p> <p>Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх 3 төрлийн сэдэвт сургалтыг төрийн болон орон нутгийн өмчит хувийн хэвшлийн 34 байгууллагын ажилтан, албан хаагч, оюутан сурагчид нийт 2585 иргэнд зохион байгуулсан. Тайлант хугацаанд тэмбүү өвчин өмнөх оны мөн үеэс 36, заг хүйтэн 8 тохиолдлоор буурч, трихоминиаз 161 тохиолдлоор нэмэгдсэн.</p> <p>БЗДХ-ын тохиолдлын тоо 122 болж өмнөх оны мөн үеэс 10.8 промилиор ихэссэн байна.</p> <p>Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зорилгоор сүрьеэгийн хавьтлын болон эрт илрүүлэг үзлэгт нийт 3134 иргэнийг хамруулж, сэжигтэй 111 иргэнээс сорьц тээвэрлэн сүрьеэгийн</p>	100		

				<p>5 шинэ тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан.</p> <p>Тайлант онд сүрьеэ өвчний 56 тохиолдол шинээр бүртгэгдсэн нь 10 000 хүн амд 6.7 болж, өмнөх оны мөн үеэс 0.1 промилиор ихэссэн байна. "Сүрьеэ өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх" сэдвээр төрийн 15 байгууллага, аж ахуй нэгж, сургууль, цэцэрлэгийн 500 ажилтан, албан хаагч, хүүхдүүдэд сургалт зохион байгуулж, 1000 ширхэг гарын авлага түгээсэн.</p>			
7	26	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ	2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;	. Аймгийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, Аймгийн Засаг даргын А/32 дугаар захирамжаар төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус төсөлд БЗДХ-аас урьдчилан сэргийлэх тархалтыг бууруулах, иргэдийг соён гэгээрүүлэх асуудлыг эрчимжүүлэн ажиллах талаар бүх шатны эрүүл мэндийн байгууллага, төрийн байгууллагуудыг үүрэгжүүлсэн, иргэний нийгмийн байгууллага, иргэд олон нийтийг уриалж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100		
	27		2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийг судлах зорилгоор Анагаах ухааны эрдэмтэн судлаачидтай хамтран Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 16,9 сая төгрөгийн санхүүжилтээр 3 сумын 442 иргэнийг оролцуулан нэг агшны судалгааг хийж, Аймгийн засаг даргын тамгын газар, ажлын хэсгийн мэргэжилтнүүдэд танилцуулгыг хийсэн.	100		
Ерөнхийлөгчийн зарлиг							
	63		1.10. Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд	Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны А/37 дугаар тушаалаар "Байгууллагын дотоод журамд" 6 дугаар зүйлийн 6.3.1-д "Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоох, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд	70		

			тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;	хариуцлага тооцох" гэсэн заалтыг оруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.			
8	98	Дүрэм шинэчлэн батлах тухай 2021-03-17 Дугаар 2021_67	3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан холбогдох дүрэм, журам, зааварт өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл цахимаар хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын нэгдсэн програмд хурлын шийдвэр, иргэдийн мэдээллийг цахимжуулж ажилладаг. Тайлант онд хөдөлмөр магадлалын хурлаар нийт 3858 иргэн орсноос шинээр 309, цуцалсан 373, сунгасан 2596, түдгэлзүүлсэн 50 иргэн тус тус байна.	100		
	99		4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, даатгуулагч (иргэн)-ийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Тайлант оны 2022 оны 03 дугаар сард Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон Өрх, сумын Эрүүл мэндийн 13 төвд Эмнэлэг, хяналтын болон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааг сайжруулах, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг бууруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн дагуу бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллахыг үүрэгжүүлсэн.	100		
	42	Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай 2020-06-01 Дугаар 2020 206	3. Хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх эмнэлгийн тусламжийн болон хүүхэд хамгааллын үйлчилгээ, сэтгэл зүй тусламж, дэмжлэг үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм шаардлагатай арга хэмжээ авах	Тайлант онд хорио цээрийн болон хязгаарлалтыг дэглэм тогтоох арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно.	-		
Ерөнхий сайдын захирамж							
9	119	Төлөвлөгөө батлах тухай 2020-07-01	2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрэгтэй, эмэгтэй хүний	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхээр аймгийн дэд хөтөлбөрийн батлан хэрэгжүүлж байна.	100		

		Дугаар 2020_99	дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)"-г хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	Эрэгтэйчүүдэд хандсан тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд Эрэгтэйчүүдийн кабинет байгуулах эхлэл тавигдаж 7 хоногийн 1 өдөр үзлэг хийж 200 орчим хүнийг үзлэгт хамруулж, 30 гаруй хүнийг мэс заслын тусламж үйлчилгээнд хамруулж, хяналтанд авсан байна. Дундаж наслалт 2020 оны жилийн эцсийн байдлаар 69,78 болж өмнөх оныхоос 0,09 насаар нэмэгдсэн. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 0.02 насаар нэмэгдсэн. (2019 онд насны зөрүү 8.4 байсан бол 2020 онд 8.6 болсон)			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
10	139	2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл 2021-09-15 Дугаар 2021_51	Х.1.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Иргэдийг коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 3 дугаар тунд хамруулах ажлыг эрчимжүүлэх, эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх, олон нийтийг хамарсан арга хэмжээ, хурим найр, хурал, зөвлөгөөн зохион байгуулахыг хязгаарлах талаар холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт нарт тус тус үүрэг болгов;	Коронавирусийн халдвар (КОВИД-19)-ын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг эрчимжүүлэх 1 сарын аян зохион байгуулсан. Аяны хүрээнд дархлаажуулалтын 3 дугаар тунг эрчимжүүлэх ажлын хүрээнд байнгын 19, түр 26, явуулын 33 цэгүүдээр 4027 иргэнийг дархлаажуулсан. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 1800 албан хаагчдад 120 удаагийн сургалт зохион байгуулж, 2039 иргэнд сурталчилгаа мэдээлэл өгч ажилласнаар 3 дугаар тунгийн дархлаажуулалтын хамралт 7.0, 4 дүгээр тунгийн хамралт 0.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим хуудсанд давхардсан тоогоор 747 зөвлөмж байршуулан, хандалт 37360, давхардсан тоогоор 2353 төрлийн, 15730 ширхэг гарын авлага, 1 зөвлөмжийг иргэдэд түгээж ажиллалаа. Олон нийтэд халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх зорилгоор, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, 6 телевиз хамтран ажиллах гэрээг байгуулан иргэдэд мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэн түгээж ажилласан. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх	100		

			дархлаажуулалтын 1 дүгээр тун 86.9, хоёрдугаар тун 83.6, гуравдугаар тунд 44.2, дөрөвдүгээр тун 9.5 хувийн хамралттай байна. Тайлант онд 5-11 насны коронавируст халдвар (КОВИД-19)-ын дархлаажуулалтад 238 хүүхэд хамрагдсан байна.			
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ				96.6		
УИХ-ЫН ТОГТООЛ				100		
УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ				100		
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ				90.0		
ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ				100		
ЗГ-ЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ				100		
Дундаж үнэлгээ				97.7		

ТАНИЛЦСАН:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА Ч.ОЮУНАА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГА, ЭДИЙН ЗАСАГ, МЭДЭЭЛЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Я.ЭРДЭНЭТУЯА

ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН Б.ЦЭНДАРЬ